

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
БОЛДБААТАРЫН УЯНГЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 1. ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ Эрүүл мэндэд эрсдэл үүсгэгч хүчин зүйлийг бууруулж хүний амьдрах, ажиллах эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх							
1.	Агаарын тухай хууль 21.4 ЭМЯ-ны төлөвлөгөө 37 Арга хэмжээ 1.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид аруин цэврийн хамгаалалтын бүс тогтоож, жагсаалт батлуулсан байх	Эрүүл мэндийн сайдын тушаал	-	Жагсаалт сайдын тушаалаар батлагдсан байна.	Хугацаа болоогүй	2025 оны 3 дугаар улирал	-
2.	АХ-2050, зорилт 2.2.8, МУХТЖҮЧ- 2.2.2, ЗГҮАХ 2.3.1.2, ЭМЯ-ны төлөвлөгөө 48-2 Арга хэмжээ 1.2. “Орчны эрүүл мэнд” 2025-2028 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах /төсөв 8 тэрбум.төг/	Эрүүл мэндийн сайдын тушаал	“Орчны эрүүл мэнд” 2021-2024 арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжилт 60%	Ажлын хэсгийн тушаал батлуулж, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна.	Орчны эрүүл мэндийн төлөвлөгөө боловсруулахад Төрийн нарийн бичгийн даргын 2/1343 дугаар албан бичгээр 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдөр холбогдох байгууллагуудаас ажлын хэсэгт нэр авч, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/166 дугаар тушаалаар 21 хүний бүрэлдэхүүнтэй салбар хоорондын ажлын хэсгийг байгуулсан.	2025.03.20 2025.12.31	100%

					Тус ажлын хэсэг 2 удаа биеэр, 1 удаа цахимаар хуралдаж төлөвлөгөөний төслийг эхний байдлаар боловсруулаад байна. 2025 оны 3 дугаар улиралд багтаан өргөтгөсөн хэлэлцүүлэг хийж арга хэмжээний төлөвлөгөөг сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.		
3.	Арга хэмжээ 1.3. Дотоод орчны агаарын чанарын стандарт батлуулах	“Дотоод орчны агаарын чанарын-техникийн ерөнхий шаардлага” MNS XXXX:2025 стандарт	-	Стандартын төслийг холбогдох зөвлөл, хороодоор хэлэлцүүлж батлуулсан байна.	Дотоод орчны агаарын чанарын стандартын төслийг боловсруулах ажлын хэсэг 2024 оноос хойш нийт 3 удаа шинэчлэгдэн батлагдсан бөгөөд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/12 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс стандартын төслийг эцэслэн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Стандарт хэмжил зүйн газрын Байгаль орчин, Эрүүл мэндийн хамтарсан техникийн хороогоор хэлэлцүүлж нэр томьёо, хамрах хүрээ хэсгийг сайжруулан 7 дугаар сарын 1-ний дотор дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.	2025.01.10 2025.07.01	70%
4.	Арга хэмжээ 1.4. Хүрээлэн буй орчин - Эрүүл мэнд 6 ажлын хэсгийн ажиллах журам боловсруулж батлуулсан байх	Хамтарсан тушаал	Эрүүл мэндийн сайд, Байгаль, орчин аялал жуулчлалын сайд /тухайн үеийн нэрээр/-ын 2023 оны хамтарсан А/482, А/657	Журмын төсөл боловсруулж, хэлэлцүүлсэн байх	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Барилгын хөгжлийн төв, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, ДЭМБ-ын төлөөллийн ажлын хэсгийн гишүүд 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хэлэлцүүлэг хийж 6 ажлын хэсгийн ажиллах журмын төсөл дээр ажилласан бөгөөд 4 ажлын хэсэгтэй, ажиллах журамтай байхаар журмын төслийг боловсруулсан. 2025 оны 3 дугаар улиралд багтаан журмын төслийг батлуулахаар ажиллаж байна.	2025.01.10 2025.07.01	100%

			дугаар тушаал				
ЗОРИЛТ 2. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
5.	Арга хэмжээ 2.1 Уур амьсгалын үндэсний хорооны 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөн өөс хамаарах заалтыг хэрэгжүүлэх	Дэд арга хэмжээ 2.1.1 Уур амьсгалын эрсдэлийг бууруулах, нөлөөллийг багасгах хариу арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	6204	ЭМЯ-ны хариуцах ажлын хэрэгжилт 30%- д хүрсэн байна.	Уур амьсгалын өөрчлөлтэд тэсвэртэй, хүрээлэн буй орчинд ээлтэй эрүүл мэндийн байгууллага - сургагч багшийн сургалтыг эхний ээлжинд 40 сургагч багш бэлтгэн цаашид үргэлжлүүлэн сургалт хийхээр удирдамж, төлөвлөгөө гарган бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025.03.01 2025.07.01 30%
6.		АХ 2.2, 6.4, МУХТЖҮЧ 2.2.2, 2.2.8, 6.4.2 Дэд арга хэмжээ 2.1.2 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, мэргэжилтний уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, эрсдэл багатай даван туулахад шаардлагатай нотолгоог бий болгож, хариу арга хэмжээний	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөтэй ЭМБ-ын тоо, хувь	-	Эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээний судалгаа хийгдсэн байх, байгууллагад хүргэсэн байна.	Уур амьсгалын өөрчлөлтөд эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхыг үнэлэх судалгаа 2024 оны 12 дугаар сард Улаанбаатар хот болон 21 аймгийг төлөөлөх удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 1200 хүн, 9 дүүрэг, 8 аймагт хийгдэж дууссан бөгөөд тус судалгааны үр дүнг холбогдох байгууллагуудад хүргэх үр дүнгийн хурлыг нэгдсэн байдлаар 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.	2025.01.10 2025.07.01 100%



		чадавхийг бэхжүүлэх						
7.		АХ 6.4, МУХТЖҮЧ 6.4.2, ОЭМҮХ 3.1.1, ҮТХНЗАХТ 3.7.3 Дэд арга хэмжээ 2.1.3. Нийгмийн эрүүл мэндийг уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүдэлтэй өвчлөл эндэгдлээс хамгаалах зөвлөмж боловсруулах	-	Зөвлөмж		Хугацаа болоогүй	2025.07.01 205.12.31	-
8.	Арга хэмжээ 2.2 Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ын хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөний төсөлд санал өгсөн байх NDC3.0	Салбарын хэлэлцүүлэг зохион байгуулж, төлөвлөгөөнд санал тусгасан байх	NDC2.0	Салбарын хэлэлцүүлэг зохион байгуулж төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна.	Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх урт хугацааны хөгжлийн стратеги боловсруулах салбар дундын ажлын хэсэгт орж ажилласан. Эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан төслийг 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдөр эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ТББ, нийгэмлэгийг хамруулан 40 гаруй бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)”-ийн	2025.01.10 2025.07.01	100%	

					зорилтыг ахиулан шинэчлэх үүрэг бүхий 11 дэд ажлын хэсэг байгуулан олон улсын түнш байгууллагын дэмжлэгтэйгээр тус баримт бичгийг 2025 оны 06 дугаар сард Засгийн газраар хэлэлцүүлэн, батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.		
ЗОРИЛТ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
9.	Арга хэмжээ 3.1. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зөвлөлийг хуралдуулж холбогдох шийдвэрийг гаргуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Зохион байгуулсан хурлын тоо	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зөвлөл шинэчлэн байгуулах тухай А/169 дүгээр тушаал	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зөвлөлийн хурлыг зохион байгуулж ажилласан байна.	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зөвлөлийг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хуралдуулсан бөгөөд тус хурлаар хэлэлцсэн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийхээр судалгааны баг, багийн ажиллах журмыг ажлын албанд байгуулсан. Өмнөговь аймгийн Засаг даргад зөвлөлийн шийдвэр болон эмнэлзүйн баг ажиллахтай холбоотой зардал гаргах, үнэлгээг 2 дугаар улиралд эхлүүлэх, хамтран ажиллах тухай Эрүүл мэндийн сайдын 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 1а/2140 тоот албан бичгийг хүргүүлсэн.	2025.01.10 2025.07.01	100%
ЗОРИЛТ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
10.	Хог хаягдлын тухай хууль 8.3.2 ЭМЯ-ны төлөвлөгөө 32 Арга хэмжээ 4.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам,	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/230 дугаар тушаал	Эрүүл мэндийн сайдын тушаал батлуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/173 дугаар тушаал батлуулж, 2025 оны 21-ний өдөр 7259 дугаарт Захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгүүлсэн. Мөн актаас бусад эмнэлгийн хог хаягдлыг зохицуулах журмыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар	2025.01.10 2025.07.01	100%

	аргачлал, зааврыг шинэчлэн батлуулах				сарын 09-ний өдрийн А/193 дугаар тушаалаар батлуулсан.		
11.	Эрүүл ахуйн тухай хуулт 4.5 ЭМЯ-ны төлөвлөгөө 34 Арга хэмжээ 4.2. Хүн, мал, амьтанд тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг боловсруулж батлуулах	Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хамтарсан тушаал	-	Ажлын хэсэг байгуулж, аргачлал боловсруулсан байна.	Хугацаа болоогүй	2025 оны 3 дугаар улирал	-
ЗОРИЛТ 5. ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
12.	Арга хэмжээ 5.1. Хүүхдийн байгууллагын гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах	Оролцсон үйл ажиллагааны тоо	-	-	Тайлагнах хугацаа болоогүй. Боловсрол, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/53, А/37 дугаар тушаал “Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 3.4, 4.3, 4.4, 4.5, 4.10 дугаар заалтуудад санал өгч хамтран ажилласан. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр хэрэгжиж буй “Боловсрол, эрүүл мэндийн салбар дахь эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилт” замын зураглал боловсруулах төслийн судалгааны ажилд оролцож байна. Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны бодит байдал, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад тооцох талаар тоон мэдээлэл цуглуулах, мэдээллээр ханган ажиллаж байна.	2025.01.10 2025.07.01	70%

					2025 оны 6 дугаар сарын 4, 12-ны өдрүүдэд салбар дундын хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцсон.		
ЗОРИЛТ 6. ХАРИУЦСАН АСУУДЛААР ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
13.	Арга хэмжээ 6.1. Орчны эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны тэмдэглэлт өдрийг зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох	Санал боловсруулсан сургалт, сурталчилгааны материалын тоо, видео шторкны тоо	-	Эрүүл мэндийг дэмжих сангийн тэргүүлэх чиглэлд агаар, орчны асуудлыг тусгах санал өгсөн байна.	Эрүүл мэндийг дэмжих сангийн тэргүүлэх чиглэл батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/100 дугаар тушаалд орчин, хөрс, хүрээлэн буй орчны талаар оруулах тухай санал өгч батлагдсан. “Дэлхийн усны өдөр 2025” Монгол орны мөсөн голуудыг хайрлан хамгаалья сэдвийн хүрээнд 6 төрлийн инфографикийг НЭМҮТ, Барилгын хөгжлийн төв, Усны газар, ДЭМБ-тай хамтран боловсруулж олон нийтэд хүргэсэн. НЭМҮТ-өөс боловсруулан гаргасан “Угаарын хийн хордлого”-оос сэргийлэх чиглэлээр гарч буй инфографик, шторк, мэдээлэлд бүрт тухай бүр санал өгч яамны цахим хуудаст байршуулж иргэдэд түгээн ажиллаж байна.	2025.01.01 2025.07.01	100%
14.	Арга хэмжээ 6.2. Эрүүл мэндийн ажилтнуудыг орчны эрүүл мэндийн чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	-	-	Хугацаа болоогүй	2025.07.01 2025.12.31	-
15.	Арга хэмжээ 6.3. Ард иргэдэд орчны бохирдол тэр дундаа хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаа зохион байгуулах	Арга хэмжээний тайлан	-	Үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	Агаарын бохирдол, утааны асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүрээнд Агаарын бохирдол – Хүний эрүүл мэнд сэдвээр Төрийн нарийн бичгийн дарга илтгэл танилцуулахтай холбоотой харьяа эрүүл мэндийн байгууллагын оролцоог хангах, салбарын мэдээлэл бэлтгэн нэгтгэх дэд	2025.01.01 2025.07.01	70%

					ажлын групп үүсгэн тухайн цаг үеийн 3 удаагийн хэлэлцүүлэгт оролцсон. Иргэдийг орчны бохирдлоос сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 133 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийслэлийн айл өрхийн хэрэглээний нүүрсний дээжийг Бээжингийн их суруулийн итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлэн шинжлүүлэх ажлыг ДЭМБ-ын дэмжлэгээр НЭМҮТ-тэй хамтран зохион байгуулсан. Агаарын бохирдлыг бууруулах иргэдэд сайжруулсан түлшний хэрэглээг сурталчлах зорилгоор нийслэлийн айл өрх, үйлдвэр, байгууллагын нүүрс шаталт, ялгаруулалтын нөхцөл байдлыг шинжлэх үнэлэх Бээжингийн Их сургуулийн судлаачдын багийг газар дээр нь ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулж, нийслэлийн СХД, Налайх, Байнзүрх дүүргийн нийт 6 айл өрх болон СЭМҮТ-ийн нам даралтын зуухны ялгаралтын хэмжилтэд ажилласан.		
16.	Арга хэмжээ 6.4. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилан, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан ЭМБ-ын ажилтнуудын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан байх	Сургалт, оролцогчдын тоо	-	ЭМБ-ын ажилтнуудын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан байх	Глобал сангийн дэмжлэгтэйгээр Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран орон нутгийн сургалтыг 21 аймаг, 9 дүүрэг, Төрөлжсөн мэргэшлийн 13 эмнэлэг, тусгай мэргэжлийн 3 төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэдлэг, чадавх дээшлүүлэх сургалтын ажлыг эхлүүлсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу Архангай, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн БОЭТ, Нэгдсэн эмнэлэг болон	2025 оны 3 дугаар улирал	100%

					сумдын ЭМТ-д томилогдон сургалтын үйл ажиллагааг эхлүүлээд байна. Тус сургалтаар 2025 онд 800 гаруй хүнийг хамруулахаар төлөвлөсөн.		
ЗОРИЛТ 7. ХАРИУЦСАН АСУУДЛААРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
17.	Арга хэмжээ 7.1. Салбар дундын хамтын ажиллагааг хангах	Оролцсон үйл ажиллагааны тоо	-	Хамаарах үйл ажиллагаанд оролцсон байх	- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Агаарын чанар. Техникийн шаардлага MNS4585:2016” стандартын төсөл боловсруулах ажлын хэсэг ажиллаж стандартыг батлуулсан. - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/93 дугаар тушаалаар батлагдсан “Лагийн менежментийн урт хугацааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл”-д ажиллаж байна. Тус зөвлөл байгуулагдсанаас хойш 3 удаа хуралдсан.	2025.01.01 2025.07.01	100%
18.	Арга хэмжээ 7.2. Төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн зохицуулалт	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-		НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв дэх Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний ажлын албатай хамтран Хүүхдийн хар тугалганы өртөлтийн эх үүсвэрийг тодорхойлох судалгааг эхлүүлсэн, зардлын тооцоо болон нарийвчилсан төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 4	2025.01.01 2025.07.01	100%

					дүгээр сарын 29-ний өдөр батлуулж НЭМҮТ-тэй гэрээ хийн ажиллаж байна.		
19.	Арга хэмжээ 7.3. Хариуцсан асуудлаар албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг тайлагнасан байх	Боловсруулсан албан бичиг, өргөдөл, гомдлын тоо	-	Тайлан гарсан байх	Ирсэн бичгийн тоо – 127 Явсан бичгийн тоо - 65 Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо - 3 Хугацаа хоцроосон бичиг - 0	2025.01.01 2025.07.01	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Биелэлт		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6		
1.	Чиг үүргийн хүрээнд ОУ-ын хуралд оролцсон байх	Оролцсон хурлын тоо	-	Хуралд оролцсон байх	ДЭМБ-ын Номхон Далайн Баруун Бүсийн Хорооны 76-р чуулганы Уур амьсгалын өөрчлөлт, орчны эрүүл мэнд хэсгийн хуралд 2025 оны 3 дугаар сарын 31-ээс 4 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд цахимаар оролцсон.		2025.01.01 2025.07.01	100%
2.	Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Сургалтын сертификат	Зохих сургалтад хамрагдсан байх	-	Хугацаа болоогүй		2025.06.01 2025.12.01	-

ТАЙЛАН БИЧСЭН:

Орчны эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Б.Уянга / /

2025.06.10